



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөлөнбуйр сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2021/136/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын

менежер: И.Сэмжидмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Semjidmaai@audit.gov.mn

Аудитор: Ж.Баяртуул

Утас: 70584207 Цахим хаяг: Bayartuulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч

Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	10
3.4. Материаллаг байдал	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Залруулсан алдаа.....	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	13
Аудитын зөвлөмж.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	14
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	14

1.Хараат бус аудиторын дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

ддд 1.0д.18 № 80
танай _____-ны № _____-т

Г ХӨЛӨНБУЙР СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Д.АЛИМАА ТАНАА

Г Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөлөнбуйр сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөлөнбуйр сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөлөнбуйр сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

011020107



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	227,036,817.16	225,136,774.17
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	20.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	20.00
3121	Төгрөг	-	20.00
31213	Арилжааны банк дахь харицах		20.00
33	АВЛАГА	30,356,300.00	12,702,576.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	456,926.00
335	Бусад авлага	30,356,300.00	12,245,650.00
3351	Байгууллагаас авах авлага	30,356,300.00	12,245,650.00
35	БАРАА МАТЕРИАЛ	166,980,517.16	171,396,779.17
354	Хангамжийн материал	11,541,798.16	16,176,060.17
35410	Бичиг хэргийн материал	-	34,400.00
35420	Аж ахуйн материал	11,161,798.16	11,161,798.16
35440	Түлш, шатах тослох материал	-	270,862.01
35470	Бусад хангамжийн материал	380,000.00	4,709,000.00
35600	Мал амьтад	155,438,719.00	155,220,719.00
36	НӨӨЦИЙН БАРАА	29,700,000.00	41,037,399.00
36300	Тэжээлийн нөөц	29,700,000.00	41,037,399.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,606,020,827.29	3,785,545,493.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,606,020,827.29	3,785,545,493.90
391	Газар		
392	Биет хөрөнгө	3,541,783,347.31	3,721,873,203.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	518,328,811.39	638,836,374.39
39202	Хуримтлагдсан элэгдэл	(84,663,094.64)	(114,041,785.81)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	202,055,400.00	202,055,400.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(84,393,414.30)	(105,604,144.38)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	168,889,359.17	236,361,762.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	(122,450,765.67)	(136,267,721.23)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,809,147.00	33,098,572.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,516,519.28)	(20,139,684.00)
39209	Зам, гүүрийн байгууламж	2,581,000,000.00	2,581,000,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(129,049,999.92)	(193,574,999.88)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,177,108,123.63	1,346,564,320.63
39215	Хуримтлагдсан элэгдэл	(695,333,700.07)	(746,414,889.93)
393	Биет бус хөрөнгө	64,237,479.98	63,672,289.94
39301	Програм хангамж	4,175,250.00	4,175,250.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,203,770.02)	(2,768,960.06)
39303	Бусад биет бус хөрөнгө	62,266,000.00	62,266,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,833,057,644.45	4,010,682,268.07
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	831,772.14
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	831,772.14
413	Өглөг	-	831,772.14
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	821,752.14
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	10,000.00
4136	Бусад өглөг	-	20.00
41361	Байгууллагад төлөх өглөг		20.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,833,057,644.45	4,009,850,495.93
51	Засгийн газрын хувь оролцоо	3,833,057,644.45	4,009,850,495.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
		733,797,873.75	733,797,873.75
51101	Өмч: - төрийн	733,797,873.75	733,797,873.75
512	Хуримтлагдсан үр дүн	2,956,813,765.86	3,133,606,617.34
51210	Өмнөх үеийн үр дүн	2,956,813,765.86	2,956,813,765.86
51220	Тайланг үеийн үр дүн	-	176,792,851.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	142,446,004.84	142,446,004.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,833,057,644.45	4,010,682,268.07

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	765,924,784.00	826,048,124.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	352,883,997.00	392,994,388.00
120	Нийтлэг татварын бус орлого	352,883,997.00	392,994,388.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	352,883,997.00	392,994,388.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	600,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	351,883,997.00	392,394,388.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	413,040,787.00	433,053,736.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	90,694,187.00	63,183,136.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчиг бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,105,000.00
131103	ЗГНХЗДНХерөнгө, гүүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	1,673,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,533,287.00	32,245,766.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27,160,900.00	28,159,370.00
131106	Төсвийн урамшуулал	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	322,346,600.00	369,870,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	322,346,600.00	369,870,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	563,435,427.12	643,821,772.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	542,787,927.12	643,821,772.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	540,470,797.62	621,377,500.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	215,072,166.34	258,240,505.00
210101	Үндсэн цалин	209,378,833.34	250,943,977.00
210102	Нэмэгдэл	-	100,628.00
210104	Урамшуулал	5,693,333.00	7,195,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,341,003.57	31,474,494.05
210201	Тэтгэврийн даатгал	18,005,021.28	21,526,318.17
210202	Тэтгэмжийн даатгал	2,110,482.50	2,532,508.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,678,146.00	2,019,286.42
210204	Ажилгүйдлийн даатгал	413,395.80	489,053.86
210205	Эрүүл мэндийн даатгал	4,133,957.99	4,907,327.58
2103	Байр шингэлттэй холбоотой тогтмол зардал	8,658,377.00	11,797,010.15
210301	Гэрэл, цахилгаан	3,730,257.00	3,906,250.15
210302	Түлш, халаалт	4,928,120.00	7,890,760.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,118,137.00	21,908,712.14
210401	Бичиг хэрэг	4,097,400.00	3,247,300.00
210402	Тээвэр, шатахуун	17,508,587.00	11,870,922.14
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,231,000.00	5,919,120.00
210404	Ном, хэвлэл	281,400.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	999,750.00	871,370.00
2105	Нормативт зардал	710,000.00	630,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	80,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	630,000.00	630,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,705,492.47	12,109,170.00
210601	Багаж, техник хэрэгсэл	132,500.00	509,300.00
210602	Тавилга	13,000.00	-
210604	Урсгал засвар	7,559,992.47	11,599,870.00
2107	Томиллолт, зочны зардал	8,818,500.00	3,270,000.00
210702	Дотоод албан томилолт	8,818,500.00	3,270,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,490,602.00	1,721,176.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	180,000.00	150,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	292,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	546,660.00	412,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	265,776.00	318,876.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	582,500.00	210,300.00
210807	Газрын төлбөр	215,666.00	215,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	240,556,519.24	280,226,433.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,704,216.00	97,025,511.85
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	184,852,303.24	183,200,921.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,317,129.50	22,444,271.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,085,800.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,085,800.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,231,329.50	22,444,271.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,231,329.50	22,444,271.94
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,647,500.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	20,647,500.00	-
223001	Бусад хөрөнгө	20,647,500.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	202,489,356.88	182,226,351.48
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	5,433,500.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	5,433,500.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(5,433,500.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	202,489,356.88	176,792,851.48

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	504,433,084.47	462,933,398.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,000,000.00	600,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,000,000.00	600,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,000,000.00	600,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	600,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	503,433,084.47	462,333,398.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	181,086,484.47	92,462,798.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчил бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,105,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрсөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	1,673,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	148,925,584.47	61,525,428.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27,160,900.00	28,159,370.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	322,346,600.00	369,870,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	322,346,600.00	369,870,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	423,208,439.47	462,933,398.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	423,208,439.47	462,933,398.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	390,535,009.97	428,243,476.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	215,403,667.50	258,001,086.27
210101	Үндсэн цалин	209,710,334.50	186,484,721.27
210102	Нэмэгдэл	-	61,072,472.00
210104	Урамшуулал	5,693,333.00	10,443,893.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,053,000.00	31,349,086.64
210201	Тэтгэврийн даатгал	17,639,800.00	21,312,670.52
210202	Тэтгэмжийн даатгал	2,101,200.00	2,513,282.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,674,500.00	2,010,628.00
210204	Ажилгүйдлийн даатгал	417,800.00	501,169.00
210205	Эрүүд мэндийн даатгал	4,219,700.00	5,011,339.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,595,257.00	11,897,370.15
210301	Гэрэл, цахилгаан	3,730,257.00	3,906,250.15
210302	Гүлш, халаалт	4,865,000.00	7,991,120.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,108,237.00	22,886,840.00
210401	Бичиг хэрэг	4,291,500.00	3,221,500.00
210402	Гэвэр, шатахуун	11,304,587.00	12,016,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,231,000.00	6,820,120.00
210404	Ном, хэвлэл	281,400.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	999,750.00	828,470.00
2105	Нормативт зардал	710,000.00	630,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	80,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	630,000.00	630,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,341,908.47	14,168,870.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	23,272,000.00	1,806,000.00
210602	Тавилга	7,487,716.00	280,000.00
210604	Урсгал засвар	7,582,192.47	12,082,870.00
2107	Томилолт, зочны зардал	8,818,500.00	3,270,000.00
210702	Дотоод албан томилолт	8,818,500.00	3,270,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,422,802.00	1,750,876.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	180,000.00	150,000.00
210802	Аулиг, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	292,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	546,660.00	412,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	265,776.00	318,876.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,514,700.00	240,000.00
210807	Газрын төлбөр	215,666.00	215,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,081,638.00	84,289,347.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	65,081,638.00	84,289,347.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,673,429.50	34,689,921.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,085,800.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,085,800.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,231,329.50	22,444,271.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,231,329.50	22,444,271.94
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татвас, санхүүжилт	30,356,300.00	12,245,650.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,356,300.00	12,245,650.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	81,224,645.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	81,224,645.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	81,224,645.00	-
223001	Бусад хөрөнгө	81,224,645.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(81,224,645.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	733,797,873.75	142,446,004.84	2,956,813,765.86	3,833,057,644.45
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	733,797,873.75	142,446,004.84	2,956,813,765.86	3,833,057,644.45
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	733,797,873.75	142,446,004.84	2,956,813,765.86	3,833,057,644.45
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	733,797,873.75	142,446,004.84	2,956,813,765.86	3,833,057,644.45
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	733,797,873.75	142,446,004.84	2,956,813,765.86	3,833,057,644.45
D08	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	176,792,851.48	176,792,851.48
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	733,797,873.75	142,446,004.84	3,133,606,617.34	4,009,850,495.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	372,219,700.00	348,026,328.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	372,219,700.00	348,026,328.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	372,219,700.00	348,026,328.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	265,731,700.00	250,603,586.27
210101	Үндсэн цалин	201,283,600.00	186,484,721.27
210102	Нэмэгдэл	64,448,100.00	61,072,472.00
210104	Урамшуулал	-	3,046,393.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэ	34,608,300.00	31,349,086.64
210201	Тэтгэврийн даатгал	23,761,400.00	21,312,670.52
210202	Тэтгэмжийн даатгал	2,689,300.00	2,513,628.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,151,000.00	2,010,280.00
210204	Ажилгүйдлийн даатгал	538,800.00	501,169.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,467,800.00	5,011,339.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,029,100.00	11,897,370.15
210301	Гэрэл, цахилгаан	3,823,100.00	3,906,250.15
210302	Түлш, халаалт	8,206,000.00	7,991,120.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,819,900.00	21,794,490.00
210401	Бичиг хэрэг	3,559,700.00	3,221,500.00
210402	Тээвэр, шатахуун	12,150,000.00	11,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,357,300.00	6,820,120.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	752,900.00	752,870.00
2105	Нормативт зардал	630,000.00	630,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	630,000.00	630,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	99,000.00	99,000.00
210604	Урсгал засвар	99,000.00	99,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,520,000.00	3,270,000.00
210702	Дотоод албан томилолт	3,520,000.00	3,270,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,690,200.00	1,488,076.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	150,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	292,500.00	292,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	371,000.00	318,876.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00
210807	Газрын төлбөр	215,700.00	215,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,091,500.00	26,894,719.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,091,500.00	26,894,719.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	80,217,148.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	80,217,148.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	80,217,148.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,397,500.00
210104	Урамшуулал	7,397,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,092,350.00
210402	Тээвэр, шатахуун	1,016,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,069,870.00
210601	Багаж, техник хэрэгсэл	1,806,000.00
210602	Тавилга	280,000.00
210604	Урсгал засвар	11,983,870.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	112,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	112,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,544,628.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,544,628.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	92,462,798.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	92,462,798.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,105,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,673,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	61,525,428.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	28,159,370.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хөлөнбуйр сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Д.Алимаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 22-ноос 2021 оны 02 дугаар сарын 16-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Баяртуул хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хөлөнбуйр сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Төрийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хөлөнбуйр сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөлөнбуйр сумын Засаг даргын тамгын газрын 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Хөлөнбуйр сумын Засаг даргын тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 болон 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өмнөх жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 563,453.4 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 11,269.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны үр дүнгийн

тайлангийн зардлын 643,821.8 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 12,876.5 мянган төгрөг болгон материаллаг байдлыг өөрчлөв.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөлөнбуйр сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 177,624.7 мянган төгрөгөөр буюу 4.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	30,3563	12,702.6	(17,653.7)
Урьдчилгаа			
Бараа материал	196,680.5	171,396.8	(25,283.7)
Үндсэн хөрөнгө	3,606,020.8	3,826,582.9	220,562.1
Нийт хөрөнгө	3,833,057.6	4010,682.3	177,624.7
Өр төлбөр		831.8	831.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,833,057.6	4,009,850.5	176,792.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,833,057.6	4,010,682.3	177,624.7

Авлага дансны үлдэгдэл 12,702.6 мянган төгрөг болж 17,653.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны өмнөх онд төсвийн төвлөрүүлэн захирагчид татуулсан хулгана устгалын зардлыг авлагаар бүртгэсэн байсныг буцаан авсан тул авлага буурснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 212,434.2 мянган төгрөг болж 15,753.7 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 вирус халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор хангамжийн материалыг өмнөх оноос 12.4 хувиар, өвөлжилт хүндэрч болзошгүйгээс шалтгаалан нөөц өвсний хэмжээг 38.2 хувиар тус тус нэмэгдүүлснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,785,545.5 мянган төгрөг болж 179,524.7 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаар 359,101.9 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 4,623.7 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн харин 1,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг сумын ИТХ-ын тогтоолын дагуу акталж, тайлант жилийн элэгдлийн зардал нь 183,200.9 мянган төгрөгийн болсон байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,009,850.5 мянган төгрөг болж 179,792.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Хөлөнбуйр сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 60,123.3 мянган төгрөгөөр буюу 7.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь халдвар хамгаалалтын дэглэмийг сахиулахад шаардлагатай тусгай зориулалтын бараа материал болон үнэ төлбөргүй шилжүүлсэн үндсэн хөрөнгийн орлогоос шалтгаалж нэмэгдсэн байна.

Нийт зардал өмнөх оноос 85,819.9 мянган төгрөгөөр буюу 15.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс 20.0 хувь, бараа

үйлчилгээний бусад зардал 16.5 хувь, төвлөрүүлэх шилжүүлэг 1,722.8 хувиар тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 369,026.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 369,026.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 3,193.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 372,219.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 хэмжээг санхүүжүүлэхээр 372,219.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 359,973.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 20,245.8 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 336,929.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, харилцахын үлдэгдэл болон туслах үйл ажиллагааны орлого 35,290.6 мянган төгрөг, нийт 372,219.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 349,775.4 мянган төгрөгийг зарцуулж 22,444.3 мянган төгрөгийг орон төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 348,026.3 мянган төгрөг буюу 93.5 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 21,212.1 мянга, түлш халаалтын зардлыг 131.7 мянга, тээвэр шатахууны зардлыг 750.0 мянга, шуудан холбооны зардлыг 537.2 мянга, бичиг хэргийн зардлыг 238.2 мянга, томилолтын зардлыг 250.0 мянга, бусдаар гүйцэтгүүлэх бараа ажил үйлчилгээний зардлыг 202.1 мянга, бараа ажил үйлчилгээний бусад зардал 871.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 1,105.0 мянга, засаг даргын нөөц хөрөнгөөс 1,673.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 61,525.4 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 28,159.4 мянга, нийт 92,462.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс малчны урамшуулалд 7,397.5 мянга, тээвэр шатахууны зардалд 1,016.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 75.6 мянга, эд хогшлын зардалд 14,069.9 мянга, бусдаар гүйцэтгэх зардалд 112.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 57,544.6 мянга нийт 80,217.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 12,245.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 138 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлж, 13 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож шилэн дансны цахим хуудсанд байршуулсан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 зарлагын 13.4 сая төгрөгийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5,500.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 30,200.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	5,500.0	1	5,500.0	-	-	-
Албан шаардлага	1	30,200.0	1	30,200.0	-	-	-
Зөвлөмж	1	0	1	0	-	-	-
Нийт дүн	3	35,700.0	3	35,700.0	-	-	-

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11,970.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 11,970.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 13,361.6 мянган төгрөгийн, Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтай холбоотой 11,970.4 мянган төгрөгийн зөрчилд тус тус албан шаардлага хүргүүлээ.

1. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 зарлагын 13,361.6 мянган төгрөгийн гүйлгээг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалттай нийцэхгүй, хэмжилт, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлээ.

2. Сумын Засаг даргын захирамжаар нийт 11,970.4 мянган төгрөгийг тухайн шатны төсөвт хамаарах ч урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан нь Сангийн Сайдын 2018 оны 318 дугаар "Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын 1.2 дахь "Энэ журмын 1.1-д заасан "урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан" гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг төсвийн зардлын зүйлс, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно" гэсэн заалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлээ.

Аудитын зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй болно.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Хөлөнбуйр сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2020			ДОА-2021/136/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<i>Хөлөнбуйр сумын ЗДТГ</i>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 зарлагын 13,361.6 мянган төгрөгийн гүйлгээг байршуулаагүй	13,361.6	Албан шаардлага	Дарга	Д.Алимаа
2	Сумын Засаг даргын захирамжаар нийт 11,970.4 мянган төгрөгийг тухайн шатны төсөвт хамаарах ч урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан	11,970.4	Албан шаардлага	Дарга	Д.Алимаа
ДҮН		25,332.0			

